


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН
ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО
БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2025 оны эхний 1 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **1,992.3** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 11.9 хувь буюу 268.6 сая ам.доллараар буурч, гадаад худалдааны тэнцэл 46.0 сая ам.долларын

ашигтай гарсан байна. Монгол Улсын гол худалдааны түнш болох БНХАУ, ОХУ зэрэг улсуудын эдийн засгийн өсөлт удааширсан нь гадаад худалдааны эргэлтийг буурахад нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 1 сар				Өөрчлөлт	
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	1,096.1	1,765.7	2,260.9	1,992.3	-268.6	-11.9
-Экспорт	539.6	1,077.7	1,324.9	1,019.2	-305.7	-23.1
-Импорт	556.5	688.0	936.0	973.2	37.2	4.0
Тэнцэл	-16.9	389.7	388.9	46.0	-342.9	-88.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2025 оны эхний 1 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **46.0** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 342.9 сая ам.доллараар буурахад импорт 37.2 сая ам.доллараар өсч, экспорт 305.7 сая ам.доллараар буурсан.

Экспорт: Экспортод **1,019.2** сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **23.1 хувиар буурахад** гол экспортын бүтээгдэхүүн болох нүүрсний олон улсын зах зээлийн үнэ болон тоо хэмжээ буурсан нь нөлөөлсөн байна.

Импорт: Импортоор нийт **973.2** сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2024 оны мөн үеэс 37.2 сая ам.доллараар буюу **4.0 хувиар өссөн** байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Монгол Улс дэлхийн 47 оронд бараа экспортолсноос БНХАУ-д 91.0 хувь, Швейцарт 7.0 хувь, ОХУ-д 0.5 хувь тус тус ногдож нийт экспортын 98.5 хувийг дээрх орнууд эзэлж байна. Экспортын барааны нийт дүнд эрдэс бүтээгдэхүүн 889.7 сая ам.доллар буюу 87.3 хувь, эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт 129.5 сая ам.доллар буюу 12.7 хувийг эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 23.7 хувиар буурсан нь манай улсын гол экспортын бүтээгдэхүүн болох нүүрсний үнийн уналтаас шалтгаалсан байна. 2025 оны эхний 1 сард нүүрсний экспортын дундаж үнэ нэг тонн дутамд **86.2** ам.долларт болж өнгөрсөн оны мөн үеэс **35.5** ам.доллараар буюу 29.2 хувиар буурсан нь манай улсын экспортын орлого буурахад голлох нөлөөг үзүүлжээ.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 1 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	342.4	875.6	1,165.8	889.7	-276.1	-23.7	87.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	197.2	202.1	159.1	129.5	-29.6	-18.6	12.7
Нийт экспорт	539.6	1,077.7	1,324.9	1,019.2	-305.7	-23.1	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 44.1 хувийг нүүрс, 25.9 хувийг зэсийн баяжмал, 7.0 хувийг алт, 4.3 жоншны баяжмал, төмрийн хүдэр 4.1 хувийг тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний 1 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2024	2025	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	124.1	135.1	11.0	8.9
Нүүрс	сая.тн	6.6	5.2	-1.4	-21.1
Төмрийн хүдэр	мян.тн	596.2	560.8	-35.4	-5.9
Цайрын баяжмал	мян.тн	5.8	16.1	10.2	176.0
Алт	тн	0.3	0.8	0.5	160.0
Боловсруулаагүй нефть	сая.баррель	0.4	0.3	-0.1	-20.4
Катодын зэс	тн	360.1	620.6	260.5	72.3
Жоншны баяжмал	мян.тн	105.1	183.6	78.5	74.7
Адууны мах	мян.тн	1.9	1.9	0.0	0.6
Өлөн гэдэс	тн	69.5	217.3	147.8	212.5
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	0.8	0.5	-0.3	-40.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	39.0	0.8	-38.2	-97.9
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	0.8	0.7	-0.1	-15.6
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	2.0	0.9	-1.1	-53.3
Самнасан ноолуур	тн	95.9	6.5	-89.4	-93.2
Угаасан ноолуур	тн	35.4	-	-35.4	-100.0
Хонины самнаагүй ноос	мян.тн	0.7	0.1	-0.6	-85.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	Эхний 1 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2024	2025	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	220.2	263.5	43.4	19.7	25.9
Нүүрс	803.1	449.0	-354.2	-44.1	44.1
Төмрийн хүдэр	47.4	41.5	-5.9	-12.4	4.1
Цайрын баяжмал	7.8	25.9	18.1	232.4	2.5
Алт	20.8	71.1	50.2	240.9	7.0
Боловсруулаагүй нефть	27.1	21.6	-5.5	-20.1	2.1
Катодын зэс	2.8	5.5	2.7	93.3	0.5
Жоншны баяжмал	22.5	43.4	20.9	93.2	4.3
Адууны мах	6.7	6.8	0.1	1.4	0.7
Өлөн гэдэс	1.2	1.5	0.2	18.4	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.03	0.01	-0.02	-68.9	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.36	0.01	-0.34	-95.9	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.00	0.03	0.03	0.0	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	0.40	0.09	-0.31	-78.5	0.0
Самнасан ноолуур	9.80	0.75	-9.0	-92.3	0.1
Угаасан ноолуур	1.60	-	-1.6	-100.0	-
Хонины самнаагүй ноос	0.73	0.11	-0.6	-85.2	0.0
Нийт экспортод эзлэх хувь	88.5	91.3			91.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 5. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ

/сая ам.доллар/

Барааны нэр	Хэмжих нэгж	Эхний 1 сар		Өөрчлөлт	
		2024	2025	Дүн	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	121.8	86.2	-35.5	-29.2
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,773.9	1,950.0	176.1	9.9
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	79.5	74.1	-5.4	-6.8
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,338.8	1,612.5	273.6	20.4
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	213.8	236.5	22.7	10.6
Молибдены баяжмал	тн/ам.дол	13,467.1	16,731.0	3,263.9	24.2
Алт	кг/ам.дол	67,028.9	87,864.5	20,835.5	31.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспортод голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2025 оны эхний 1 сарын гүйцэтгэлээр 449.0 сая ам.долларын 5.2 сая.тн чулуун нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 354.2 сая ам.доллар буюу 44.1 хувиар, биет хэмжээ 1.4 сая. тн буюу 21.1 хувиар тус тус буурсан байна. Чулуун нүүрсний экспортын дундаж үнэ 86.2 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 29.2 хувиар буурсан байна. Чулуун нүүрсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Зэсийн баяжмал: 2025 оны эхний 1 сарын байдлаар 263.5 сая ам.долларын 135.1 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 43.4 сая ам.доллар буюу 19.7 хувиар, биет хэмжээгээр 11.0 мян.тн буюу 8.9 хувиар тус тус өссөн байна. Нэг тонн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 1,950.0 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 9.9 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр: 2025 оны эхний 1 сарын гүйцэтгэлээр 41.5 сая ам.долларын 560.8 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 5.9 сая ам.доллар буюу 12.4 хувиар, биет хэмжээгээр 35.4 мян.тн буюу 5.9 хувиар тус тус буурсан байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна. Нэг тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 74.1 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 6.8 хувиар буурсан байна.

Алт: 2025 оны эхний 1 сарын гүйцэтгэлээр 71.1 сая ам.долларын 808.7 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 50.2 сая ам.доллар буюу 2.4 дахин, биет хэмжээгээр 497.7 кг буюу 1.6 дахин тус тус өссөн байна. Нэг кг алтны экспортын дундаж үнэ 87,864.5 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 31.1 хувиар өссөн байна. Алтыг 100 хувь Швейцар руу экспортолсон байна.

Жоншны баяжмал: 2025 оны эхний 1 сарын байдлаар 43.4 сая ам.долларын 183.6 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 78.5 мян.тн буюу 74.7 хувиар, үнийн дүнгээр 20.9 сая ам.доллар буюу 93.2 хувиар тус тус өссөн байна. Нэг тонн жоншны баяжмалын экспортын дундаж үнэ 236.5 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 10.6 хувиар өссөн байна. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын 91.1 хувийг БНХАУ, 8.7 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

Боловсруулаагүй нефть: 2025 оны эхний 1 сарын гүйцэтгэлээр 21.6 сая ам.долларын 0.3 сая.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 0.1 сая.бар буюу 20.4 хувиар, үнийн дүнгээр 5.5 сая ам.доллар буюу 20.1 хувиар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

“2025 оны эхний 1 сард нүүрсний үнэ үнийн уналтаас үүдэн манай улсын нүүрсний экспортын орлого 44.1 хувиар буурсан нь улсын төсөвт сөрөг нөлөө үзүүлж байна. Гэвч зэс, алтны экспортын хэмжээ болон үнэ өссөн нь нүүрсний экспортын орлогын бууралтыг тодорхой хэмжээгээр нөхөж байна”.

2025 оны эхний 1 сард эрдэс бүтээгдэхүүний үнэ нь нэр төрөл бүрээр эрс ялгаатай байна. Дэлхийн зах зээлд үнэт металл (алт), стратегийн металлууд (молибден, цайр, зэс) эрэлт нэмэгдсэн. Технологийн дэвшил, “ногоон шилжилт” эдгээр бүтээгдэхүүний үнийг дэмжиж байна. Нүүрсний үнэ буурсан нь экологийн шаардлага, эрчим хүчний шинэ төрлүүдэд шилжих хандлагын илрэл юм.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Манай улс дэлхийн 104 орноос гарал үүсэлтэй бараа импортолсноос БНХАУ-д 32.6 хувь; ОХУ-д 26.5 хувь; Японд 14.5 хувь; АНУ-д 7.2 хувь; ХБНГУ-д 3.8 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 84.6 хувийг эзэлж байна.

Нийт импортын 23.7 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 76.3 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний

импорт тус тус эзэлж байна.

Импортоор нийт **973.2** сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2024 оны мөн үеэс 37.2 сая ам.доллараар буюу 4.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 1 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	131.6	180.2	221.9	230.8	8.8	4.0	23.7
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	424.9	507.8	714.05	742.41	28.4	4.0	76.3
Нийт импорт	556.5	688	936.0	973.2	37.2	4.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импорт өсөхөд эрдсийн бүтээгдэхүүн 23.1 хувь, машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 63.2 хувь, авто, агаарын

ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги 72.7 хувь, хүнсний бүтээгдэхүүн 28.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Эхний 1 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2024	2025	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	9.6	10.9	1.3	13.5	1.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	8.7	18.6	9.9	113.8	2.0
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	4.9	4.0	-0.9	-18.4	0.4
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	54.6	70.1	15.5	28.4	7.5
5	Эрдэс бүтээгдэхүүн	180.2	221.9	41.7	23.1	23.7
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	37.3	40.9	3.6	9.7	4.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	28.5	25.3	-3.2	-11.2	2.7
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	0.7	0.6	-0.1	-14.3	0.1
9	Мод, модон эдлэл	4.4	6.4	2.0	45.5	0.7
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	6.6	7.1	0.5	7.6	0.8
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	2.5	3.0	0.5	20.0	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	17.8	17.8	0.0	0.0	1.9
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	0.2	0.3	0.1	50.0	0.0
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	47.3	55.0	7.7	16.3	5.9
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	104.5	170.5	66.0	63.2	18.2
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	144.2	249.0	104.8	72.7	26.6
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	11.0	11.7	0.7	6.4	1.3
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	14.3	0.1	-14.2	-99.3	0.0
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.0	12.0	12.0	0.0	1.3
21	Бусад	0.2	-	-0.2	-100.0	0.0
	ДҮН	688.0	936.0	248.0	36.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импорт өсөхөд голлон нөлөөлсөн бараа, бүтээгдэхүүн

Суудлын автомашин импорт:

Онцгой албан татвартай суудлын автомашиныг 2025 оны эхний 1 сард 15,129 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 716 ширхэг буюу 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 659 ширхгээр, бусад суудлын автомашин 57 ширхгээр тус тус өссөн.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Барааны төрөл	Тоо хэмжээ		Өөрчлөлт		Татварын дүн		Өөрчлөлт	
	2024.I	2025.I	Дүн	Хувь	2024.I	2025.I	Дүн	Хувь
Хос тэжээлт	12,173.0	12,832.0	659.0	5.4	93.7	106.3	12.6	13.5
Бусад	2,240.0	2,297.0	57.0	2.5	34.7	39.3	4.6	13.2
Нийт	14,413.0	15,129.0	716.0	5.0	128.4	145.6	17.2	13.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлшний импорт:

Монгол Улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2025 оны эхний 1сард 250.7 мян. тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Төрөл	Барааны төрөл	Тоо хэмжээ /мян.тн/		Өөрчлөлт		Ногдуулсан татварын дүн		Өөрчлөлт	
		2024.I	2025.I	Дүн	Хувь	2024.I	2025.I	Дүн	Хувь
Автобензин	A-80	1.7	0.1	-1.7	-96.0	0.7	0.0	-0.7	-95.9
	A-92	78.4	80.7	2.3	2.9	21.7	22.1	0.4	2.0
	A-95 болон түүнээс дээш	2.5	1.5	-1.0	-40.2	0.5	1.0	0.5	90.4
Дизель түлш		129.9	168.4	38.5	29.6	56.0	67.3	11.3	20.2
Нийт		212.6	250.7	38.1	17.9	78.9	90.4	11.5	14.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага 2025 оны эхний 1 сард Улсын төсөвт 553.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 555.4 тэрбум төгрөг төвлөрч, гүйцэтгэл 100.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024.I	2025.I		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Орлогын биелэлтийн хувь
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Хувь
Нийт орлого	534.9	553.7	555.4	20.5	3.8	100.3
Татварын дүн	525.3	541.6	543.4	18.1	3.4	100.3
Гаалийн албан татвар	133.9	144.5	143.7	9.8	7.3	99.4
Нэмэгдсэн өртгийн албан татвар	305.0	307.8	305.5	0.5	0.2	99.3
Архи, дарсны онцгой албан татвар	4.3	4.1	3.9	-0.4	-9.3	95.1
Тамхины онцгой албан татвар	11.4	8.4	10.8	-0.6	-5.3	128.6
Шар айрагны онцгой албан татвар	0.4	0.8	0.8	0.4	100.0	100.0
Суудлын автомашины онцгой албан татвар	67.5	73.3	75.9	8.4	12.4	103.5
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	0.5	0.3	0.3	-0.2	-40.0	100.0
Автобензин, дизель түлшний албан татвар	2.3	2.4	2.5	0.2	8.7	104.2
Экспортын татвар	-	-	-	0.0	-	-
Хураамж	8.6	10.9	10.8	2.2	25.6	99.1
Өөрийн орлого	1.0	1.2	1.2	0.2	20.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 20.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Гаалийн албан татвар 9.8 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 8.4 тэрбум төгрөг;
- Хураамжийн орлого 2.2 тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртгийн албан татвар 0.5 тэрбум;
- Шар айргийн онцгой албан татвар 0.4 тэрбум төгрөг;
- Өөрийн орлого 0.2 тэрбум төгрөг;
- Автобензин дизелийн түлшний албан татвар 0.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин тамхины онцгой албан татвар 0.6 тэрбум төгрөг автобензин, архи, дарсны онцгой албан татвар 0.4 тэрбум төгрөг, дизелийн түлшний онцгой албан татвар 0.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Татвараас чөлөөлөгдсөн импорт нь 2025 оны эхний сард 115.5 тэрбум төгрөгт хүрч, түүнд ногдуулсан 17.3 тэрбум төгрөгийн татварыг хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна.

- 1) Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан тусламжийн хүрээнд 12.4 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 1.9 тэрбум тэрбум төгрөг;
- 2) БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016-09-07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-аар Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг нь 30.1 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 4.7 тэрбум төгрөг;
- 3) Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг болох 1.2 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 0.2 тэрбум төгрөг;
- 4) Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 5.3 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 0.8 тэрбум төгрөг;
- 5) ХАА-ын зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис бүхий нийт 0.03 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 0.003 тэрбум төгрөг;
- 6) Бусад татварын хуулийн зүйл заалтуудаар 17.6 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд 2.2 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Хүснэгт 11. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024.I		2025.I		Өөрчлөлт	
	Импортын дүн	Чөлөөлсөн татвар	Импортын дүн	Чөлөөлсөн татвар	Импортын дүн	Чөлөөлсөн татвар
ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	2.2	0.2	0.0	0.0	-2.2	-0.2
Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	16.4	2.5	12.4	1.9	4.1	-0.6
Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ болон газрын тосны компаниудын тоног төхөөрөмж	37.6	5.8	30.1	4.7	-7.5	-1.2
Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	0.3	0.0	1.2	0.2	1.0	0.2
Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	11.0	1.7	40.8	6.3	29.8	4.6
Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	15.5	2.4	5.3	0.8	-10.2	-1.6
Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	5.8	0.9	8.2	1.3	2.4	0.4
Бусад	147.1	22.7	17.6	2.2	-129.5	-20.5
Нийт	235.9	36.3	115.5	17.3	-112.3	-19.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС